

**“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙНХЭЭ ЭРХИЙГ ХАМГААЛАХ,
ТЭДГЭЭРТЭЙ ХАРЬЦАХ ХАРИЛЦААНЫ ЖУРАМ**

Баримт бичгийн нэр:	ХЭ-ийн эрхийг хамгаалах, тэдгээртэй харьцах харилцааны журам
Боловсруулсан нэгж:	ТУЗ
Хэрэгжилтэд хяналт тавих:	ТУЗ
Хамаарах нэгж:	ТУЗ болон ГЗ-ын холбогдох нэгж

Агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Компанийн хувьцаа эзэмшигч, түүний эрх
3. ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэхэд компаниас хэрэгжүүлэх ажиллагаа
4. Жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах хүрээнд хийх ажиллагаа
5. Бусад зүйл

НЭГ. Нийтлэг зүйл

- 1.1 Энэхүү журмыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексын хүрээнд хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, мөн тэдгээртэй компанийн зүгээс харьцах харилцаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү журмын зорилго нь компаниас өөрийн хувьцаа эзэмшигчтэй харьцах харилцаа болон тэдгээрийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компаниас хийх ёстой ажиллагаа зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Компанийн хувьцаа эзэмшигч, түүний эдлэх эрх

- 2.1. Хувьцаа эзэмшигч (цаашид ХЭ гэх) гэж тус компанийн гаргасан энгийн хувьцааг зохих үнээр худалдан авсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
- 2.2. ХЭ нь дараах үндсэн эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.2.1 ХЭХ-д хуульд заасны дагуу оролцох, санал өгөх;
 - 2.2.2 Компани ногдол ашиг хуваарилсан тохиолдолд ногдол ашиг авах;
 - 2.2.3 Өөрийн эзэмшиж буй хувьцаагаа хүссэн үедээ бусдад худалдах;
 - 2.2.4 Компани татан буугдах үед бусдад өгөх өглөгөө төлсний дараа өөрт ногдох хөрөнгөө авах;
 - 2.2.5 Компанийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар тодорхой мэдээлэл өөрийн зардлыг зарцуулж авах;
- 2.3. ХЭ нь дор дурдсан нөхцөл үүсэхэд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.3.1 Компани шинээр хувьцаа гаргах үед уг үнэт цааснаас өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээнд тохирох хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах;
 - 2.3.2 Нэг буюу түүнээс дээш хувийн ХЭ нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 2.3.3 Нийлэх, нэгтгэх болон өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдах, дүрэмд өөрчлөлт орох нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд эсрэг саналтай байсан, мөн санал хураалтад оролцоогүй ХЭ хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
 - 2.3.4 Нэг этгээд энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд ХЭ хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;

Гурав. ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэхэд компаниас хэрэгжүүлэх ажиллагаа

- 3.1. Компани нь ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэх, хамгаалахад ерөнхий зохион байгуулалтын хүрээнд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.1.1 Компанийн зүгээс ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах, эрхээ хамгаалахад нь туслалцаа үзүүлэх зорилготой бүтэц болон ажилтаныг томилон ажиллуулах;
 - 3.1.2 Компанийн зүгээс бүх хувьцаа эзэмшигчид тэгш хандаж, эзэмшиж буй хувьцааных нь хэмжээнд үндэслэн холбогдох үүргийг хүлээх;
 - 3.1.3 Компани нь хувьцаа эзэмшигчидтэйгээ харилцах үр ашигтай сувгийг бий болгон ажиллуулах;
 - 3.1.4 ХЭ нь компанид хохирол учруулсан этгээдээс нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргахад нь компаниас туслах;

3.2. ХЭХ-д оролцож хурлаар хэлэлцэх асуудал болон хурлаас шийдвэрт санал өгөх эрхийг нь хэрэгжүүлэх хүрээнд компаниас дараах ажлыг зохион байгуулж гүйцэтгэнэ. Үүнд:

3.2.1. ХЭХ хуралдуулахтай холбоотой дараах мэдээллийг хурал болохоос 40-өөс доошгүй хоногийн өмнө ХЭ-ийн харьцдаг үнэт цаасны компаниар дамжуулан хүргэсэн байна:

- a. Хурал болох хугацаа, болох газрын нэр, хаяг;
- b. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл;
- c. Тухайн хуралд оролцох ХЭ-ийн нэрсийг гаргах бүртгэлийн өдөр;
- d. Хурлаас гарах шийдвэрт ХЭ-ийн санал өгөх саналын хуудас;
- e. Хурлаас гарах шийдвэртэй холбоотой танилцуулах, тайлбар өгөх материалууд

3.3 Дээр дурдсан материалыг өөрийн цахим хуудаст тавихаас гадна олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хурал болохоос өмнө 2-оос доошгүй удаа мэдээлнэ.

3.4 ХЭ-ээс компанийн үйл ажиллагаатай танилцах, компаниас шаардлагатай мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх, ХЭ-ээс компанийн үйл ажиллагаатай холбоотой санал, шүүмжлэл, гомдол гаргах, тэдгээрийг хүлээн авч шийдвэрлэх хүрээнд компани дараах ажлыг хэрэгжүүлнэ.

- a. Компанийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажуулсан санхүүгийн байдлын тайлан, балансыг улирал бүр гаргаж өөрийн цахим хуудсаар дамжуулан ХЭ болон бусад сонирхогч талуудад хүргэх ажлыг зохион байгуулж байна.
- b. Компанийн ХЭ-ийн ээлжит хурлын үед Компанийн тухай хуулийн 65.6-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудаст байршуулах, бусад бололцоот арга хэрэгслийг ашиглан ХЭ болон бусад сонирхогч талуудад үзэх, танилцах бололцоог хангасан байна.
- c. Компанийн зүгээс ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ХЭ-ээс ирүүлэх санал, шүүмжлэл, гомдлыг хүлээн авч холбогдох этгээдэд нь дамжуулан өгч шийдвэрлүүлэн хариуг уг санал, гомдол гаргасан ХЭ-д мэдэх үүрэгтэйгээр ажиллуулна.

3.5. ХЭ-ийн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн үндсийг хангах хүрээнд Компанийн тухай хуулийн 45.1, 45.2-т заасны дагуу тэдгээрийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлүүлэх талаар үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

3.6. ХЭ-ийн ногдол ашиг авах эрхийг хэрэгжүүлэх хүрээнд компани ашигтай ажилласан тохиолдолд цэвэр ашгаас Компанийн тухай хуулийн 47.1-д заасан нөхцөлийг хангасны дараа ХЭ-дээ ногдол ашиг хуваарилах ба компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой харилцааг зохицуулсан тусгайлсан журамтай байна. Энэхүү журамд ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг олгох хөрөнгийн эх үүсвэр, ХЭ-д олгох журам, хугацаа, олгогдоогүй ногдол ашгийг хадгалах журам, хуваарилсан ногдол ашгийг нягтлан бодох бүртгэлд тусгах асуудал зэргийг тусгасан байна.

3.7. ХЭ-ийн бусад эрхийн хувьд тухайн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл байдал үүссэн тухай бүр компанийн зүгээс хийх, хэрэгжүүлэх ёстой ажиллагааг тухай бүр нь ХЭ-д аль болох шуурхай, чирэгдэл багатайгаар шийдэхэд нь бүрэн туслалцаа үзүүлж ажиллана.

Дөрөв. Жижиг хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах хүрээнд хийх ажиллагаа

4.1. Компани нь өөрийн ХЭ-ийг эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр нь ялгаварлан хандах бодлого баримталдаггүй боловч том ХЭ (хяналтын хувиас дээш хэмжээний хувьцаа эзэмшигчид) нь компанийн эрх барих байгууллагууд (ХЭХ, ТУЗ, ГУ)-д өөрсдөө болон өөрийн төлөөлөл нь тодорхой албан тушаал хашиж байдаг тул компанийн зүгээс ХЭ-ийн эрхийг хамгаалах ажлыг гол нь жижиг

ХЭ (хувьцааны хяналтын хувиас доош тооны хувьцаа эзэмшигч)-ийн эрхийг хамгаалахад чиглүүлсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасны дагуу компанийн зүгээс жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах хүрээнд компанийн зүгээс дараах бодлогыг хэрэгжүүлж ажиллах болно:

- a. Жижиг ХЭ-д ХЭХ-ын материал болон хурлаас гарах шийдвэрийн төслийг хүлээн авч танилцаад хурал болохоос өмнө саналаа өгөх эрхийг нь хэрэгжүүлэх үүднээс хурлын материалыг хурал болохоос 40-өөс доошгүй хоногийн өмнө бэлтгэн тэдгээрт хүргүүлэх журмыг хэрэгжүүлнэ. Энэ асуудлыг ХЭХ-ыг хуралдуулах журамд тодорхой тусгасан байна.
- b. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд жижиг ХЭ-ийн төлөөллийг оролцуулах үүднээс ТУЗ-ийн гишүүдийг сонгоход куммлятив аргыг хэрэглэх. Энэ талаар ТУЗ-ийн гишүүдийн нэр дэвшүүлэх, сонгох журамд тодорхой заасан байна.
- c. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны үнэ буурахаас хамгаалах үүднээс Том ХЭ-ээс хувьцаагаа худалдах тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчээс эзэмшиж буй хувьцааныхаа үнийг бууруулахгүй байхын тулд тэдгээрт дараах эрхийг эдлүүлэхийг зорих болно.
 - i. Хувьцааг хамт худалдуулах;
 - ii. Хувьцаа худалдах худалдаанд татан оролцуулах;
 - iii. Бусдаас өмнө авах;
 - iv. Эхэлж татгалзах;
 - v. Эхэлж гэрээг хийх;
- d. Компани шинээр хувьцаа гаргахад Жижиг ХЭ-д эхэлж худалдан авах эрх олгох;
- e. Компанийн ХЭ-ийн болон ТУЗ-ийн хурлаас гарах шийдвэрт жижиг хувьцаа эзэмшигчдийг нөлөө үзүүлэх хэмжээнд оролцуулахын тулд дараах арга ажиллагаа, зарчмыг хэрэгжүүлнэ:
 - i. ХЭ-ийн болон ТУЗ-ийн хурлаар шийдэх чухал асуудлыг өндөр хувиар шийдэх зарчмыг баримтлах;
 - ii. Асуудлыг шийдэхэд жижиг ХЭ болон тэдний төлөөллийг оролцуулах арга, механизмыг хэрэглэх;
 - iii. ХЭ-ээс ХЭХ-ыг хуралдуулах санал гаргах, хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах бололцоог хангах, ирүүлсэн саналыг нь хэрэгжүүлэх ажлыг зохих журмын дагуу хэрэгжүүлдэг байх;
 - iv. ХЭХ-д жижиг ХЭ-ээс бага зардлаар, төвөг багатай, хамгийн хялбараар саналаа өгөх бололцоог хангах үүднээс саналыг саналын хуудсаар авах, саналын хуудасны бүрдүүлбэрийг саналаа бүрэн хэмжээнд өгөхөөр тодорхой ойлгомжтой болгосон байх

4.3. ХЭ-ээс дараах эрхээ хэрэгжүүлэхэд нь компанийн зүгээс зохих туслалцааг үзүүлэх:

- a. ХЭХ-аас гаргасан шийдвэрт эсрэг саналтай, эсвэл уг хуралд оролцоогүй ХЭ хүсвэл өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид (том ХЭ)-д худалдан авахыг шаардах эрх;
- b. Компанийн хууль болон дүрмийн заалтыг зөрчсөн эсвэл компанид хохирол учруулах шийдвэрийг хүчингүй болгохоор шүүхэд гомдол гаргах эрх;
- c. Зөрчил байгаа гэж үзвэл хараат бус шалгалт хийлгэх санал гаргах эрх;
- d. Өөрт учирсан хохирлоо барагдуулах талаар нэхэмжлэл гаргах эрх;

- е. ТУЗ болон бусад удирдлагаас зүй бус үйлдэл гаргасан гэж үзвэл түүнийг арилгуулах, сэргээх шалгалт оруулах, нэхэмжлэл гаргах эрх;

Тав. Бусад зүйл

- 5.1. Энэхүү Журамд ТУЗ-ийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд Журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 5.2. Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно.

ooOoo